

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ОРЛОГЫН 80 ХУВИЙГ МАЛЧДААС САНАЛ
АВААГҮЙ АРГА ХЭМЖЭЭНД ТӨЛӨВЛӨСӨН НЬ МАЛЧДЫН АМЬДРАЛД ЧИГЛЭСЭН
БОДИТ ҮР ДҮНГЭЭ ҮЗҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛАГДАЖ ЧАДАХГҮЙ БАЙНА

АУДИТЫН СЭДЭВ: МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ

АУДИТЫН КОД: ГСА-2024/34-ШТА-ГА

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа,
Утас: 70543179

Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Наранбаяр, Утас:70543179

Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Анхтуяа, Утас: 70543179

Цахим хаяг: ankhtuyab@audit.gov.mn

Аудитор С.Батцэцэг, Утас: 70543179

Цахим хаяг: battsetsegsa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn

Тайланг бэлтгэсэн:

Говьсүмбэр аймаг дахь
Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор
Б.Сарантуяа

Аудитын менежер

Г.Наранбаяр

Ахлах аудитор

Б.Анхтуяа

Аудитор

С.Батцэцэг

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл байвал
70543179 дугаарын утсаар
харилцана уу.

ХАЯГ:

Сүмбэр сум 3-р баг,
Нутгийн удирдлагын
ордон, 206 тоот

2024 оны 06 дугаар сар

АГУУЛГА

АГУУЛГА 2

Малын тоо толгойн албан татварын орлогын бүрдүүлэлт 54.8 хувьтай, 132,395.8 мянган төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн байна 8

1.1. Малын тоо толгойн албан татварын орлогыг үндэслэлтэй төлөвлөөгүй байна..... 8

1.2. Малын тоо толгойн албан татварын орлогын бүрдүүлэлт 54.8 хувьтай байна. 12

1.3. Малын тоо толгойн 2021, 2022 оны албан татварын тайланг малчид, мал бүхий этгээдүүд 2023 онд нөхөж бүрэн тайлагнасан байна. 15

Малын тоо толгойн албан татварын орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний 34.5 хувь нь орлого бүрдүүлэлтээс хамаарч хэрэгжээгүй байна. 15

2.1. Малын тоо толгойн албан татварын орлогоос малчин иргэдийн санал аваагүй төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн, малчдын өгсөн саналын 28.5%-ийг төсөл арга хэмжээнд хамруулсан нь малчдын амьдралд чиглэж бодит үр дүнгээ үзүүлж чадахгүй байна..... 15

2.2 Малын тоо толгойн албан татварын орлогоор санхүүжүүлсэн хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгасан хэдий ч зарим хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаагүй байна. 20

Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна 21

3.1. Малын тоо толгойн албан татварын орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй, удирдлага мэдээллийн системд бүрэн мэдээлээгүй байна. 21

Дүгнэлт

Зөвлөмж

Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал

Шалгагдагч байгууллагын санал тайлбар

Тайлан баталгаажуулах тушаал

Тайлангийн хавсралтууд

ТОВЧИЛСОН ҮГС

ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
МЭҮН	Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж
МЭГ	Мал эмнэлгийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СХДАА	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТГ	Татварын газар
ТЕГ	Татварын ерөнхий газар
ХХААХҮ	Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэл
УМС	Удирдлага мэдээллийн систем
ҮСХ	Үндэсний статистикийн хороо

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитын зорилт:

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:

Аудитын хамарсан хүрээ:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” А/100, “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу нийцлийн аудитыг гүйцэтгэлээ.

Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилт, орлогын бүрдүүлэлт, зарцуулалт хууль тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийн дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Малын тоо толгойн албан татварын орлогыг хуульд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, тайлагнасан эсэх
- Малын тоо толгойн албан татварын зарцуулалт хууль журмын дагуу хэрэгжсэн эсэх
- Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан эсэх

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- Малын тоо толгойн албан татварын тухай хууль
- Төсвийн тухай хууль /23.8.15, 60.2.8 /
- Монгол Улсын 2022, 2023 оны Төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”
- Сангийн сайдын 2021 оны 160 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”
- Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”
- Татварын ерөнхий газрын даргын 2021 оны А/9 дүгээр тушаалаар баталсан “Малын тоо толгойн албан татвар ногдуулах, төлөх, тайлагнах журам”
- Сумдын ИТХ-ын тогтоолууд
- Бусад холбогдох шийдвэрүүд

Аудитад сумдын ИТХ, сумдын ЗДТГ, багийн засаг дарга нар, багийн ИНХ, СХДАА, Татварын газрын 2022, 2023 оны Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөлт, ногдуулалт, бүрдүүлэлт, зарцуулалт, хяналт шалгалтын баримт материалуудыг хамруулав.

Аудитын арга зүй:

Аудитыг MNS6817-1:2020 “Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталж, 2021 оны А/81 дүгээр тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилт, дэд зорилт, асуудлын шинжилгээнд хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, тулган баталгаажуулах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, малчин, мал бүхий иргэнээс санал, асуулга авах зэрэг аудитын арга зүйг хэрэгжүүлж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа:

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Анхтуяа, аудитор С.Батцэцэг нар хийж гүйцэтгэлээ.

Аудитын төлөвлөгөөг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр батлуулж, гүйцэтгэлийн үе шатны ажлыг 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөс 5 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл гүйцэтгэж, тайланг 06 дугаар сарын 12-ны дотор боловсруулан, ҮАГ-ын Аудитын зөвлөлийн хурлаар 06 сарын 21-ний дотор хэлэлцүүлж, тайланг дарга, Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан холбогдох байгууллага албан тушаалтанд 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдөр хүргүүлээ.

Хүндрэл бэрхшээл:

Аудитыг гүйцэтгэхэд хуулийн мэдлэг бүхий мэргэшсэн албан хаагч дутагдалтай, орон тооны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан эрх зүйч-аудитор ажиллуулах боломжгүй байна. Нийцлийн аудитыг санхүүгийн мэргэжлийн аудиторууд гүйцэтгэж байгаа нь хуулийн мэргэжлийн нэр томъёог андуурах, ойлголтын зөрүүтэй асуудал үүсэх, хууль эрхзүйн мэдлэг дутах зэрэг хүндрэл бэрхшээл үүсэж байна.

Үндсэн
мэдээлэл

УИХ-аас 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр “Малын толгойн албан татварын тухай хууль”-ийг баталж, 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн байна.

Говьсүмбэр аймгийн хэмжээнд 2021 онд 432.2 мянга, 2022 онд 464.2 мянга, 2023 онд 450.1 мянган толгой мал тоологдсон байна.

Малын тоо толгойн албан татварын хэмжээг Сүмбэр сумын ИТХ-ын 2022 оны №11, Шивээговь сумын ИТХ-ын 2021 оны №04, Баянтал сумын сумын ИТХ-ын 2020 оны №09 дугаар тогтоолоор тус тус баталсан байна.

Малын тоо толгойн албан татварын орлогоос ОНХС-д төвлөрүүлсэн хөрөнгийг дараах хууль тогтоомжийн дагуу зарцуулахаар тусгажээ. Үүнд:

1. Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8-д “Малын тоо толгойн албан татварын орлогын эх үүсвэрийг бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардал”-д зарцуулна.



2. Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.5-д заасан арга хэмжээнүүдэд зарцуулна.

Дүрслэл товьёг

<i>№</i>	<i>Тайлбар</i>	<i>Хуудасны дугаар</i>
Дүрслэл 1	Сумдын нэг толгой малд ногдох татварын хэмжээ /сумдаар/	8
Дүрслэл 2	Малын тоо толгойноос хамааран 0 төгрөгийн албан татвар ногдуулсан малын тоо	9
Дүрслэл 3	Аймгийн хэмжээнд тоологдсон малын тоо /мянган толгой/	12
Дүрслэл 4	Татварын тайлан ирүүлсэн байдал	15
Дүрслэл 5	Малын тоо толгойн албан татварын орлогын зарцуулалтын зориулалт, чиг үүрэг	17
Дүрслэл 6	Данс бүртгэлд тусгасан хөрөнгийн жагсаалт	20

Хүснэгт товьёг

<i>№</i>	<i>Тайлбар</i>	<i>Хуудасны дугаар</i>
Хүснэгт 1	Сумдын ИТХ-аас баталсан 2022, 2023 оны орлогын төлөвлөгөөний харьцуулалт	10
Хүснэгт 2	Сумдын орлогын төлөвлөгөө, Татварын нэгдсэн системд үүсгэсэн ногдуулалтыг харьцуулсан харьцуулалт	10
Хүснэгт 3	ҮСХ-ноос гаргасан малтай өрхийн тоог Татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд татвар төлөгчөөр бүртгэгдсэн малтай өрхийн тоотой харьцуулсан харьцуулалт	12
Хүснэгт 4	2022, 2023 оны малчдын тоо, татвар ногдуулалт	12
Хүснэгт 5	Сумдын 2022, 2023 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	13
Хүснэгт 6	Аймгийн хэмжээний Малын тоо толгойн албан татварын өрийн үлдэгдэл	14
Хүснэгт 7	Сумдын малчид, мал бүхий этгээдийн тоо, санал өгсөн малчдын тооны харьцуулалт	15
Хүснэгт 8	Сумдын 2022, 2023 онд малын тоо толгойн албан татварын орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалтад малчид, мал бүхий этгээдийн санал тусгагдсан байдал	16
Хүснэгт 9	Малын тоо толгойн орлогын албан татварын орлогоос санхүүжих төсөл арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл	17

БҮЛЭГ 1

Малын тоо толгойн албан татварын орлогын бүрдүүлэлт 54.8 хувьтай, 132,395.8 мянган төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн байна


1.1. Малын тоо толгойн албан татварын орлогыг үндэслэлтэй төлөвлөөгүй байна.

1.1.1 Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар албан татварын хэмжээг малын төрөл тус бүрээр тогтоосон байна.

Сумдын ИТХ-аас нэг малын тоо толгойд тухайн татварын жилд ногдуулах албан татварын хэмжээг малын төрөл тус бүрээр хуульд заасан хязгаарыг баримтлан дараах байдлаар тогтоосон байна. Үүнд:



Дүрслэл №01 Сумдын нэг толгой малд ногдох татварын хэмжээ / төгрөгөөр /




Дүрслэлээс дүгнэхэд: Бүх сумд тэмээнд ногдуулах татварын хэмжээг 0 төгрөг байхаар тогтоосон нь аймгийн хэмжээнд нийт малын төрөлд тэмээн сүргийн эзлэх хувь бага, тэмээн сүргийн тоо толгойг өсгөх бодлого барьж байгаатай холбоотой байна.

Эх сурвалж: Сумдын ИТХ-ын тогтоолууд /Сүмбэр сумын ИТХ-ын 2020 оны №11, Шивээговь сумын ИТХ-ын 2021 оны №04, 06, Баянтал сумын ИТХ-ын 2020 оны №09, Баянтал сумын 2022 оны №17/

Мөн Сүмбэр сум хонь, ямааг 500 төгрөг, Шивээговь сум үхэр, ямааг 800 төгрөг, Баянтал сум адуу, үхэрт 1000 төгрөгөөр тооцож, нэг толгойд ногдох албан татварын хэмжээг малын төрөл харгалзахгүй ижил хэмжээгээр тогтоосон нь бэлчээрийн даац, малын бэлчээрт учруулах хор хөнөөлийг тооцоогүй, үүнийг хууль журмаар зохицуулсан заалт байхгүй байна.

Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т “Малчны амьжиргааг дэмжих зорилгоор малчны өмчилж байгаа малын тоо толгойноос хамааран ногдох албан татварын хэмжээг 0 төгрөг байхаар тогтоож болно” гэж заасны дагуу сумууд дараах байдлаар малын тоо толгойноос хамааран 0 төгрөгийн албан татвар ногдуулсан малын тоог тогтоосон байна.

Дүрслэл №02 Малын тоо толгойноос хамааран 0 төгрөгийн албан татвар ногдуулсан малын тоо



Дүрслэлээс дүгнэхэд: Шивээговь сум 0 төгрөгийн албан татвар ногдуулах малын тоог тогтоогоогүй бол Сүмбэр сум малчны өмчилж байгаа адуу, үхэр тус бүрд 20, хонинд 150, ямаанд 100 толгой мал, Баянтал сум хонь, ямаа тус бүрд 50 толгой малд 0 төгрөгийн татвар тогтоосон байна.

Эх сурвалж: Сумдын ИТХ-ын тогтоолууд /Сүмбэр сумын ИТХ-ын 2020 оны №11, Шивээговь сумын ИТХ-ын 2021 оны №04, 06, Баянтал сумын ИТХ-ын 2020 оны №09, Баянтал сумын 2022 оны №17/

Сумдын ИТХ нь Малын тоо толгойн албан татварын хэмжээ болон малчны өмчилж байгаа малын тоо толгойноос хамааран ногдох албан татварын хэмжээг 0 төгрөг байхаар тогтоохдоо Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5¹-д “эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлж, санал авах” гэж зааснаар иргэдээс цахим болон цаасан хэлбэрээр авсан санал асуулгад үндэслэсэн байна.

Аудитын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх нотлох баримтыг цуглуулах явцад Сүмбэр сумын ИТХ 256 хүнээс цахимаар санал асуулга авсан талаар хуралдааны тэмдэглэлд бичигдсэн боловч санал асуулгын нэгтгэл архивын баримтаас олдоогүй, Баянтал сумын ИТХ цахимаар санал асуулга авсан талаар асуулгад дурдсан боловч архиваас баримт материал, тайлан олдоогүй гэсэн тайлбар ирүүлсэн бол, Шивээговь сумын ИТХ цаасаар 41, цахимаар 10, нийт 51 малчин өрхөөс тус тус санал асуулга авсан нотлох баримтыг ирүүлсэн.

Үүнээс харахад Сумдын ИТХ нь баримт материалыг Архивын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1², 23.2.1³, 23.2.4⁴-д тус тус зааснаар тухай бүр нь хадгаламжийн нэгж бүрдүүлэн байгууллагын архивд хүлээн авч бүртгэх үйл ажиллагааг зохион байгуулаагүй байна.

Сүмбэр, Баянтал сумдын ИТХ-аас Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3⁵ дахь заалтыг баримтлан малын тоо толгойноос хамааран татварын хэмжээг 0 төгрөгөөр тогтоохдоо хөнгөлөлт гэсэн үг хэллэгийг хэрэглэсэн нь хуулийн агуулгад нийцээгүй байгааг цаашид анхаарч ИТХ-ын тогтоол, шийдвэрийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гаргах шаардлагатай байна.

1.1.2 Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөөг мал тооллогын дүнд үндэслэн төлөвлөөгүй байна.

Говьсүмбэр аймгийн хэмжээнд 2022 онд 1,166 малчин өрхийн 464,294 толгой мал, 2023 онд 1,171 малчин өрхийн 450,143 толгой мал тоологдсон байна.

¹ эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлж, санал авах

² Байгууллагын архив тухайн байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулж, архивын баримтыг анхан шатанд бүрдүүлж, энэ хуульд заасан хугацаагаар түр хадгална

³ албан хэрэг хөтлөлтийн явцад үүссэн хавтаст баримтыг зохион байгуулалтын нэгж, ажилтнаас бүрэн бүрдэлтэй хүлээн авах

⁴ архивын баримтыг холбогдох журам, стандартын дагуу хадгалах, хамгаалах

⁵ Малчны амьжиргааг дэмжих зорилгоор малчны өмчилж байгаа малын тоо толгойноос хамааран ногдох албан татварын хэмжээг 0 төгрөг байхаар тогтоож болно.

Төсвийн тухай хуулийн 23.8-д “Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ”, 23.8.15-т “малын тоо толгойн албан татвар” гэж зааснаар малын тоо толгойн албан татвар нь сумын татварыг орлогыг бүрдүүлж байна.

Малын тоо толгойн албан татварын орлогыг сумууд 2022 онд 144,234.4 мянга, 2023 онд 148,839.7 мянган төгрөгөөр тус тус төлөвлөж, батлуулсан байна.

Сумд орлогыг төлөвлөхдөө өмнөх жилийн мал тооллогын дүнг үндэслэн тооцсон хэдий ч малчин өрх тус бүрээр малын төрөл, тоо толгой, 0 төгрөгийн татвар ногдуулах малын тоогоор нарийвчлан тооцсон мэдээллийг гаргаж ирүүлээгүй нь орлогыг үндэслэлтэй төлөвлөсөн эсэхийг тулган баталгаажуулах боломжгүй байлаа.

Хүснэгт №01 Сумдын ИТХ-аас баталсан 2022, 2023 оны орлогын төлөвлөгөөний харьцуулалт

Сумдын нэрс	2022 он	2023 он	/мянган төгрөгөөр/	
			Зөрүү	Хувь
Сүмбэр	80,729.8	84,839.7	4,109.9	5.1
Шивээговь	36,073.1	45,000.0	8,926.9	24.7
Баянтал	27,432.5	19,000.0	(8,432.5)	30.7
Дүн	144,235.4	148,839.7	4,604.3	3.2

Эх сурвалж: Сумдын ИТХ-ын 2022, 2023 оны төсөв баталсан тогтоолд үндэслэсэн аудиторын тооцоолол

Хүснэгтээс дүгнэхэд: Татварын орлогыг 2023 онд өмнөх оноос 4,604.3 мянга буюу 3.2 хувиар нэмэгдүүлэн төлөвлөсөн нь Сүмбэр, Шивээговь сумд өмнөх оны төлөгдөөгүй татварын авлагыг нэмж төлөвлөсөн бол Баянтал сум ямар шалтгаанаар бууруулан төлөвлөсөн нь тодорхойгүй, энэ талаар тайлбар ирүүлээгүй байна.

Үүнээс үзэхэд сумд орлогын төлөвлөлтийг хийхдээ тухайн жилийн татвар ногдуулахад нөлөөлөх хүчин зүйлсийг тооцоогүй, төлөгдөөгүй авлагыг нэмж тооцох болон өмнөх оны татварын орлогын төлөвлөгөөг жишиг байдлаар үндэслэн төлөвлөж иржээ.

Аймгийн Татварын хэлтэс нь Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5.2-д зааснаар албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн хэлтэсээс гаргасан өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн тооцож, татварын ногдуулалт хийх хуулийн зохицуулалттай байна.

Татварын нэгдсэн системд Малын тоо толгойн албан татварын ногдуулалтыг 2022 онд 145,816.5 мянга, 2023 онд 151,248.3 мянган төгрөгөөр тус тус тооцсон нь сумдын төлөвлөсөн орлогоос илүү дүнгээр нэхэмжлэх үүссэн байна.

Хүснэгт №02 Сумдын орлогын төлөвлөгөө, Татварын нэгдсэн системд үүсгэсэн ногдуулалтыг харьцуулбал

Сумдын нэрс	2022 оны орлогын төлөвлөгөө	2022 оны Татварын газрын ногдуулсан дүн	Зөрүү	/ мянган төгрөгөөр /		
				2023 оны орлогын төлөвлөгөө	2023 оны Татварын газрын ногдуулсан дүн	Зөрүү
Сүмбэр	80,729.8	88,446.8	7,717.0	84,839.7	87,313.6	2,473.9
Шивээговь	36,073.1	30,938.3	(5,134.8)	45,000.0	29,303.8	(15,696.2)
Баянтал	27,432.5	26,431.4	(1,001.1)	19,000.0	34,630.9	15,630.9
Дүн	144,235.4	145,816.5	1,581.1	148,839.7	151,248.3	2,408.6

Эх сурвалж: Аймгийн Татварын газраас ирүүлсэн 2022, 2023 оны ногдуулалтын мэдээ

Хүснэгтээс дүгнэхэд: Сумдын орлогын төлөвлөгөө, татварын системд үүсгэсэн албан татварын ногдуулалт хоорондоо зөрүүтэй байгаа нь сум хариуцсан татварын байцаагчийн орон тоо байгаа хэдий ч орон нутагт хүний нөөцийн дутагдалтай байдлаас шалтгаалан орон тооны байцаагч ажиллаагүй, багийн Засаг дарга, санхүүгийн албаны дарга, мэргэжилтнүүд өөрчлөгдөх, тогтвор суурьшилтай ажиллаагүй зэрэг хүчин зүйлүүд нөлөөлж, орлогын төлөвлөлт үндэслэлтэй хийгдээгүй байна.

Аудитын илрүүлэлт: Зөвлөмж

Сумууд Малын тоо толгойн албан татварын орлогыг төлөвлөхдөө малчин өрх тус бүрийн мэдээлэлд үндэслэн гаргасан тооцооллыг ирүүлээгүй, хэрхэн тооцоолсон нь тодорхойгүй, Татварын нэгдсэн системд үүсгэсэн ногдуулалтын дүнгээс жил бүр дутуу төлөвлөсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн төсвийн төслийг боловсруулж, энэ хуулийн 67.2-т заасан танилцуулгын хамт тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ” гэж заасантай нийцээгүй байна.

Сумдын Засаг дарга нарт: Малын тоо толгойн албан татварын орлогыг өмнөх оны мал тооллогын дүн, малчин өрх тус бүрийн мэдээлэлд үндэслэн бодитой төлөвлөх

1.1.3 Төрийн байгууллагуудын мэдээлэл солилцох үйл ажиллагаанд хууль журмыг баримтлан ажиллаагүйгээс малын тоо толгойн албан татварын ногдуулалт цаг хугацаандаа хийгдэхгүй байна.

Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2⁶-д зааснаар Үндэсний статистикийн хорооноос мал тооллогын нэгдсэн дүнг Татварын ерөнхий газарт ирүүлдэг бөгөөд мэдээлэлд үндэслэн албан татварыг ногдуулж, Татварын удирдлага мэдээллийн нэгдсэн системд сумын ИТХ-ын тогтоосон хувь хэмжээгээр мэдээллийн сан үүсгэдэг,

2022, 2023 онуудад өмнөх жилийн мал тооллогын дүн “Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-д 02 дугаар сарын 15-ны дотор ороогүйн улмаас ногдуулалт хугацаандаа хийгдээгүйгээс шалтгаалан аймгийн Татварын газар болон сумдаас малын тоо толгойн албан татварыг төлүүлэхэд хугацаа алдах, тоон мэдээллийн зөрүү үүсэх зэрэг хүндрэл үүссэн байна.

ТЕГ-ын даргын 2021 оны А/09 дүгээр тушаалаар батлагдсан “Малын тоо толгойн албан татвар ногдуулах, төлөх, тайлагнах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2-т “Татварын алба нь хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т заасан өмнөх жилийн мал тооллогын дүн, нэгдсэн мэдээллийг ҮСХ-ноос төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системээр дамжуулан тайлант жилийн 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүлээн авч, “Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-д холбогдох мэдээллийн санг үүсгэнэ”, Мөн Үндэсний Статистикийн хорооны дарга, Татварын газрын даргын хамтран 2022 онд байгуулсан “Мэдээлэл харилцан солилцох гэрээ”-ний 2.2-д мал тооллогын мэдээллийг дараа оны 3 сарын 1-ний дотор Татварын ерөнхий газарт хүргүүлэхээр тусгасан боловч Үндэсний Статистикийн хорооноос мэдээллийг цаг хугацаанд нь хүргүүлэхгүй байна.

Үндэсний Статистикийн хорооноос хууль журам болон гэрээнд заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүйгээс Татварын нэгдсэн системд малын тоо толгойн албан татварын ногдуулалт цаг хугацаандаа хийгдэхгүй байна. Төрийн байгууллагуудын мэдээлэл солилцох үйл ажиллагаа удаашралтай байгаагаас татварын орлого цаг хугацаандаа бүрэн төвлөрөхгүй байх эрсдэлийг бий болгож байна.

⁶ Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн татварын алба тооцож, төлбөл зохих албан татварыг тодорхойлно

2022-2023 оны ҮСХ-ноос гаргасан малтай өрхийн тоо нь Татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд татвар төлөгчөөр бүртгэгдсэн малтай өрхийн тооноос нийт 52-оор илүү байгаа нь малчдын шилжилт хөдөлгөөнтэй холбоотойгоор татварын газраас шилжилт хийлгээгүй байна.

Хүснэгт №03 ҮСХ-ноос гаргасан малтай өрхийн тоог Татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд татвар төлөгчөөр бүртгэгдсэн малтай өрхийн тоотой харьцуулбал:

Сумдын нэрс	Малтай өрхийн тоо /ҮСХ/		Малтай өрхийн тоо /ТГ/		Зөрүү	
	2022	2023	2022	2023	2022	2023
Сүмбэр	830	828	839	851	9	21
Шивээговь	176	177	189	184	13	7
Баянтал	160	166	166	162	6	(4)
Нийт дүн	1166	1171	1194	1166	28	24

Эх сурвалж: Аудиторын тооцоолол

Дүрслэл №03 Аймгийн хэмжээнд тоологдсон малын тоо /мянган толгой/



ҮСХ-ны мал тооллогын дүнгээр аймгийн хэмжээнд 2021 онд 432,196 толгой, 2022 онд 7.4%-аар өсөж 464,294 толгой мал тус тус тоологдсон байна.



Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй малын тоо толгойг ҮСХ-ноос гаргасан малын тоо толгойн дүнтэй тулгах гэсэн боловч аймгийн Татварын газар мэдээллийн сангаас хөрвөдөггүй тул татвар ногдуулсан малын тоог гаргах боломжгүй гэсэн тайлбарыг өгсөн.

Иймд малын тоо толгойн албан татварын ногдуулалт бүртгэл мэдээллийн нэгдсэн системд бүрэн үүссэн эсэхийг тогтоох боломжгүй байна.

Татварын байгууллагаас 2022, 2023 онд ногдуулсан малын тоо толгойн албан татварын орлого дараах байдалтай байна.

Хүснэгт №04. 2022, 2023 оны малчдын тоо, татвар ногдуулалтыг хүснэгтээр харуулбал:

Сумдын нэрс	2022 оны малчдын тоо	2022 оны ногдуулсан дүн	2023 оны малчдын тоо	2023 оны ногдуулсан дүн	Ногдуулалтын зөрүү
Сүмбэр	839	88,446.8	851	87,313.6	(1,133.2)
Шивээговь	189	26,431.4	184	29,303.8	2,872.4
Баянтал	166	30,938.3	162	34,630.9	3,692.6
Нийт	1194	145,816.5	1166	151,248.3	(5,431.8)

Эх сурвалж: ҮСХ-ноос гаргасан статистик мэдээ, Татварын газраас ирүүлсэн мэдээ тайланд үндэслэсэн аудиторын тооцоолол

Хүснэгтээс дүгнэхэд: 2023 онд ногдуулсан албан татварын орлого өмнөх оноос 3.7% буюу 5,431.8 мянган төгрөгөөр өссөн нь малчид болон малын тоо нэмэгдсэн, Татварын цахим системээр тайлан ирүүлсэн байдал нэмэгдсэн зэргээс шалтгаалсан байна.

1.2. Малын тоо толгойн албан татварын орлогын бүрдүүлэлт 54.8 хувьтай байна.

1.2.1. Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасны дагуу албан татварыг сумын төсөвт бүрэн төвлөрүүлээгүй, 2022-2023 онд 132,395.8 мянган төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн байна.

Аймгийн хэмжээнд 2022-2023 онд нийт 293,075.1 мянган төгрөгийн малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөө батлуулж, 160,679.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэн, төлөвлөгөөний биелэлт 54.8 хувьтай байна. Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг сум тус бүрээр дараах байдлаар харуулав.

Хүснэгт №05 Сумдын 2022, 2023 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг харьцуулбал:

Сумдын нэрс	2022		Хэрэгжилтийн хувь	2023		Хэрэгжилтийн хувь
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Сүмбэр	80,729.8	49,252.9	61.0	84,839.7	68,797.3	81.1
Шивээговь	36,073.1	8,035.4	22.3	45,000.0	13,462.9	29.9
Баянтал	27,432.5	12,687.5	46.3	19,000.0	8,443.3	44.4
Нийт	144,235.4	69,975.8	48.5	148,839.7	90,703.5	60.9

Эх сурвалж: Сумдын 2022, 2023 оны төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан

Хүснэгтээс дүгнэхэд: Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөөг сумууд бүрэн биелүүлээгүй бөгөөд хэрэгжилт 2022 онд 48.5%, 2023 онд 60.9%-тай байна.

Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө” гэсэн нь төсвийн жилийн сүүлээр татварын орлого төвлөрснөөс үүдэн төлөвлөсөн арга хэмжээ цаг хугацаандаа хэрэгжихгүй, мөн малчдын амьжиргааны орлого олох боломжтой цаг хугацаатай уялдахгүй байна.

1.2.2 Малын тоо толгойд ногдуулсан албан татварыг бүрэн төвлөрүүлэхэд аймгийн Татварын газар, сумдын Засаг дарга нарын хамтын ажиллагаа үр дүн муутай байна.

Аймгийн Татварын газар 2022, 2023 онд албан хаагчдын дунд “Малын тоо толгойн албан татвар хураах” ажлын удирдамжийг баталж хэрэгжүүлсэн байна. Удирдамжийн хүрээнд сумдтай хамтран дараах ажлыг хийж гүйцэтгэжээ.

2022	<ul style="list-style-type: none"> • Шивээговь сумын хөдөөгийн баг, Баянтал сумын 2 дугаар баг, Сүмбэр сумын 4, 5, 6 дугаар багуудын 100 гаруй малчин өрхөөр тойрч, нийт 27.0 сая төгрөгийн малын тоо толгойн албан татварыг төвлөрүүлсэн байна.
2023	<ul style="list-style-type: none"> • Сүмбэр, Шивээговь, Баянтал сумын хөдөөгийн багуудаар тойрч, 390 малчин өрхийн 25.6 сая төгрөгийн малын тоо толгойн албан татварыг төвлөрүүлсэн байна.

Аймгийн Татварын газар 2023 онд малын тоо толгойн албан татварыг хураах чиглэлээр Сүмбэр сумын Засаг даргатай хамтарсан удирдамж гаргаж ажилласан ба Шивээговь, Баянтал сумдын хувьд багийн засаг дарга нартай утсаар холбогдон малчдын дэлгэрэнгүй судалгааг гаргуулах, төлөөгүй малчдын судалгааг багийн засаг дарга нарт хүргүүлэх зэргээр хамтран ажиллажээ.

Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөөг биелүүлэхэд хүний нөөцийн дутагдалтай байдал, тогтвор суурьшил нөлөөлсөн хэдий ч аймгийн Татварын газар, сумдын хамтын ажиллагааны үр дүн, малчид, мал бүхий этгээдэд хүргэж буй мэдээлэл, сургалт сурталчилгаа үр дүн муутай байгаа нь орлогын төлөвлөгөөний биелэлтээс харагдаж байна.

Аудитын илрүүлэлт: Албан шаардлага

Сумд малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөөг 2022 онд 51.5 хувь, 2023 онд 39.1 хувиар тус тус дутуу төвлөрүүлж, төлөвлөгөөг бүрэн биелүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8⁷, 23.8.15⁸, 41 дүгээр зүйлийн 41.2⁹, 41.2.1¹⁰ дэх заалтуудтай тус тус нийцээгүй байна

Сумдын Засаг дарга нарт: Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөөний биелэлтийг сайжруулах, хяналт тавих, Татварын байгууллагатай хамтран ажиллах хамтын ажиллагааны үр дүнг дээшлүүлэх

Малчин, мал бүхий этгээдийн 2022,2023 оны малын тоо толгойн албан татварын өрийн үлдэгдлийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт №06 Аймгийн хэмжээний Малын тоо толгойн албан татварын өрийн үлдэгдэл

Тайлант он	Нэхэмжлэхийн дүн	Урьд оны барагдуулалт	2023 оны барагдуулалт	Өрийн үлдэгдэл	Барагдуулалтын хувь
2022	151,248.3	9,517.7	81,377.3	86,127.5	53.8
2023	145,816.5	36,020.2	33,880.4	75,915.9	23.23
Нийт	297,064.8	45,537.9	115,257.7	162,043.4	38.8

Эх сурвалж: 2022, 2023 оны татварын өрийн барагдуулалтын судалгаа

Хүснэгтээс дүгнэхэд: Малын тоо толгойд ногдуулсан албан татвараас 2022 онд 86,127.5 мянга, 2023 онд 75,915.9 мянган төгрөгийн татварыг төсөвт тус тус төвлөрүүлээгүй бөгөөд татвар хураалт 2022 онд 53.8 хувь, 2023 онд 23.2 хувьтай байгаа нь өмнөх оноос 50%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Аудитын илрүүлэлт: Албан шаардлага

Аймгийн Татварын газар нь 2022 онд 86,127.5 мянга, 2023 онд 75,915.9 мянган төгрөгийн малын тоо толгойд ногдуулсан малчин, мал бүхий иргэний албан татварын өрийг барагдуулах арга хэмжээг авч ажиллаагүй, нийт 162,043.4 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8¹¹, 23.8.15¹², 41 дүгээр зүйлийн 41.2.1¹³, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1¹⁴, 7.2¹⁵, ТЕГ-ын даргын 2021 оны А/09 дүгээр тушаалаар батлагдсан “Малын тоо толгойн албан татвар ногдуулах, төлөх, тайлагнах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 -д заасантай тус тус нийцээгүй байна.

Татварын газарт: Малын тоо толгойд ногдуулсан нийт 162,043.4 мянган төгрөгийн албан татварын өрийг барагдуулах

⁷ Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ:

⁸ малын тоо толгойн албан татвар

⁹ Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ

¹⁰ хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх

¹¹ Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ:

¹² малын тоо толгойн албан татвар

¹³ хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх

¹⁴ Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө

¹⁵ Албан татвар төлөгч нь албан татварыг урьдчилан төлж болно


1.3. Малын тоо толгойн 2021, 2022 оны албан татварын тайланг малчид, мал бүхий этгээдүүд 2023 онд нөхөж бүрэн тайлагнасан байна.

Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т заасны дагуу татварын тайланг малчид өөрсдөө маягтын дагуу бэлтгэж, жил бүрийн 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор татварын албанд ирүүлэхээр заасан хэдий ч цахилгаан, интернэт, утасны сүлжээ зэргээс хамааран татварын тайланг илгээх бүрэн боломжгүй нөхцөл байдал үүсдэг байна.

ТЕГ-аас Малын тоо толгойн албан татварын тайланг нөхөж авах чиглэл ирснээр 2021-2023 оны хоцроосон тайланг нөхөж 100% хүлээн авсан байна.

Дүрслэл №04 Татварын тайлан ирүүлсэн байдал

Дүрслэлээс харахад: Аймгийн Татварын газраас ирүүлсэн судалгаагаар малчид, мал бүхий этгээд 2022 онд 1034 буюу 80.5%, 2023 онд 1232 буюу 89.2% нь малын тоо толгойн албан татварын тайланг бүрэн тайлагнасан байна.



БҮЛЭГ 2

Малын тоо толгойн албан татварын орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний 34.5 хувь нь орлого бүрдүүлэлтээс хамаарч хэрэгжээгүй байна.

2.1. Малын тоо толгойн албан татварын орлогоос малчин иргэдийн санал аваагүй төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн, малчдын өгсөн саналын 28.5%-ийг төсөл арга хэмжээнд хамруулсан нь малчдын амьдралд чиглэж бодит үр дүнгээ үзүүлж чадахгүй байна.

2.1.1. Малын тоо толгойн албан татварын орлогоор 2022-2023 онд 58 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас малчид, мал бүхий иргэдийн санал аваагүй 46 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн нь нийт төсөл, арга хэмжээний 80 хувийг эзэлж байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2¹⁶, 60.2.8¹⁷-д малын тоо толгойн албан татвар нь сумын ОНХС-ийн эх үүсвэр болно гэж заасны дагуу малын тоо толгойн албан татвараар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт нь Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын дагуу хийгдэж байна.

Аймгийн хэмжээнд Малын тоо толгойн албан татварын орлогоор санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нийт 42 /2022 онд 13, 2023 онд 29/ саналыг малчид, мал бүхий этгээдээс авсан ба багийн ИНХ-аар уг саналуудын эрэмбэлсэн жагсаалтыг гарган сумдын Засаг дарга нарт хүргүүлсэн байна. Санал асуулгад хамрагдсан малчид мал бүхий иргэдийн тоог дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт №07 Сумдын малчид, мал бүхий этгээдийн тоо, санал өгсөн малчдын тооны харьцуулалт

¹⁶ Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

¹⁷ малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна.

Д/д	Сумдын нэр	Санал өгөх малчдын тоо		Санал өгсөн малчдын тоо		Хамрагдсан гүйцэтгэлийн хувь	
		2022 он	2023 он	2022 он	2023 он	2022 он	2023 он
1	Сүмбэр	891	969	238	205	26.7	21.2
2	Баянтал	209	226	-	40	0.0	17.7
3	Шивээговь	179	195	31	148	17.3	75.9
Нийт дүн		1279	1390	269	393	21.0	28.2

Эх сурвалж: ҮСХ-ноос гаргасан статистик мэдээ, сумдын санал өгсөн малчдын тооны нэгтгэл

Хүснэгтээс дүгнэхэд: Багийн ИНХ-д санал өгсөн малчид нийт малчдын 2022 онд 21.0%, 2023 онд 28.2%-ийг тус тус эзэлж байна. Малчид бага хувьтай санал өгч байгаа нь багийн ИНХ-д оролцох малчдын идэвх санаачилга муу, ирц бага, малчид, мал бүхий этгээдийн хуулийн талаарх мэдлэг хомс, багийн засаг дарга нар зар мэдээллийг хүртээмжтэй хүргэдэггүй зэрэг шалтгаантай байна.

Хүснэгт №08 Сумдын 2022, 2023 онд малын тоо толгойн албан татварын орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалтад малчид, мал бүхий этгээдийн санал тусгагдсан байдал

№	Сумдын нэр	Батлагдсан ТАХ-ний тоо		Батлагдсан ТАХ-нд малчдын саналаар эрэмбэлэгдсэн ТАХ-ний тоо		Ажлын хэсгээс нэмж баталсан ТАХ-ний тоо	
		2022 он	2023 он	2022 он	2023 он	2022 он	2023 он
1	Сүмбэр сум	20	13	3	1	17	12
2	Баянтал сум	10	1	-	1	10	-
3	Шивээговь сум	6	8	2	5	4	3
Нийт дүн		36	22	5	7	31	15

Хүснэгтээс дүгнэхэд: 2022-2023 онд нийт 58 төсөл, арга хэмжээг төлөвлөснөөс малчдын саналаар 20% буюу 12 төсөл арга хэмжээ, малчин мал бүхий иргэдийн санал аваагүй 80% буюу 46 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна. Малчин, мал бүхий иргэдээс өгсөн саналын 28.5%-ийг төсөл арга хэмжээнд хамруулжээ.

Сумд 2022-2023 онд малын тоо толгойн албан татварын орлогоор санхүүжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг дэлгэрэнгүй байдлаар арга хэмжээ тус бүрээр гаргаагүй, төсвийг бөөн дүнгээр сумын ИТХ-аар батлуулсан байна.

Аудитын илрүүлэлт: Зөвлөмж

Малын тоо толгойн албан татварын орлогоос малчин, мал бүхий иргэдээс өгсөн саналын 28.5%-ийг төсөл арга хэмжээнд хамруулж, малчин, мал бүхий этгээдээс санал аваагүй 46 төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6¹⁸, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1¹⁹, 6 дугаар хэсгийн 6.10²⁰, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12 дугаар зүйлийн 12.2.1²¹-д заасантай тус тус нийцээгүй байна.

¹⁸ орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ.

¹⁹ Баг, хорооны Засаг дарга нь сум, дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран өмнөх оны ОНХС-ийн үйл ажиллагааны үр дүн, тухайн онд ОНХС-ийн болон малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр санхүүжүүлэхээр батлагдсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй танилцуулгыг дараагийн төсвийн жилийн аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан тэргүүлэх ач холбогдолтой хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний танилцуулгын хамт бэлтгэж баг, хороо, сум, дүүргийн мэдээ, мэдээллийн хэрэгслээр дамжуулан жил бүрийн 2 дугаар сард багтаан олон нийтэд танилцуулна.

²⁰ Сум, дүүргийн Засаг дарга нь ОНХС-д төвлөрөх малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр санхүүжүүлэхээр иргэд, малчдаас гаргасан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг журмын 4.5-д заасан чиг үүргийн дагуу сум, дүүргийн бэлчээр ашиглалт, өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын төлөвлөгөөтэй тус тус уялдуулан боловсруулж ИТХ-д танилцуулж батлуулна.

²¹ баг, хорооны Засаг дарга орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг хорооны иргэдийн дунд олон нийтийн нээлттэй санал асуулгыг явуулна.

Сумдын Засаг дарга нарт: Малын тоо толгойн албан татварын орлогыг малчин, мал бүхий иргэдийн санал аваагүй төсөл арга хэмжээг батлахгүй байх, багийн ИНХ-аас гаргасан эрэмбэлсэн саналын дагуу хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг санхүүжүүлэх

2.1.2 Малын тоо толгойн албан татварын орлого бүрдүүлэлтээс шалтгаалан төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 34.5% нь хэрэгжээгүй, 20 ажил хийгдээгүй байна.

Малын тоо толгойн албан татварын орлогоор 2022-2023 онд 406,337.5 мянган төгрөгийн 58 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 239,950.0 мянган төгрөгийн 20 ажил хийгдээгүй байна. Энэ нь татварын орлогын төлөвлөгөө бүрэн биелээгүйгээс шалтгаалсан байна.

Малын тоо толгойн албан татварын тухай хуульд заасан татвар төлөх хугацаа нь Төсвийн тухай хууль, ОНХС-ийн журамтай уялдахгүй байгаагаас орлогын бүрдүүлэлтэд нөлөөлж, төлөвлөсөн арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр дутагдах, цаг хугацааны хувьд төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжихгүй нөхцөл байдал үүсэж байна.

Хүснэгт №09 Малын тоо толгойн орлогын албан татварын орлогоос санхүүжих төсөл арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл


/ мянган төгрөгөөр /

№	Сумын нэр	ТАХ-ний төлөвлөгөө				Гүйцэтгэл				Хэрэгжээгүй ажил үйлчилгээ			
		2022		2023		2022		2023		2022		2023	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	Сүмбэр	20	137,519.5	13	121,837.7	12	44,009.2	10	73,774.9	8	93,510.3	3	48,062.8
2	Баянтал	10	46,907.2	1	19,000.0	9	28,740.5	-	-	1	18,166.7	1	19,000.0
3	Шивээговь	6	36,073.1	8	45,000.0	3	6,400.0	4	13,462.9	3	29,673.1	4	31,537.1
Нийт дүн		36	220,499.8	22	185,837.7	24	79,149.7	14	87,237.8	12	141,350.1	8	98,599.9

Хүснэгтээс дүгнэхэд: Татварын орлогын төлөвлөгөө биелээгүйгээс шалтгаалсан 2022 онд нийт төлөвлөсөн төсөл арга хэмжээний 66.6%, 2023 онд 63.6%-ийг тус тус хэрэгжүүлсэн байна.

Малын тоо толгойн албан татварын орлогыг Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-д заасан зориулалт, чиг үүргээр ангилан дараах байдлаар харуулав.

Дүрслэл №05 Малын толгойн албан татварын орлогын зарцуулалтыг зориулалт, чиг үүрэг



Дүрслэлээс дүгнэхэд: 28%-ийг малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зардалд, 19%-ийг малчдад зориулсан сургалт сурталчилгааны зардалд, 15%-ийг тэжээлийн нөөц бүрдүүлэх зардалд, 15%-ийг малын чанарыг сайжруулах зардалд, 9%-ийг хортон мэрэгчидтэй тэмцэх зардалд, 5%-ийг байгаль орчныг хамгаалах зардалд, бэлчээрийн менежмент сайжруулах, малын тэжээлийн ургамал тариалах зардалд 4%, бусад чиг үүрэгт заагаагүй зардалд 5%-ийг тус тус зарцуулсан байна.

Олгосон санхүүжилтийн 5.0 хувийг зориулалт бус хуульд заасан чиг үүрэгт хамааралгүй дараах төсөл арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулсан байна. Үүнд:

Баянтал сум-2,500.0 мянга /Газарзүйн байршлын цэг тэмдэглэгээ тогтоох ажлыг зохион байгуулах /

Сүмбэр сум-6,333.2 мянга /Малчдын өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдалтай танилцах, Пос машин худалдан авах, өвөлжөө хаваржааны солбилцол тодорхойлох /

Аудитын илрүүлэлт: Зөвлөмж

Сүмбэр, Баянтал сум ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 4.5-д заасан чиг үүрэгт хамааралгүй төсөл, арга хэмжээнд нийт 8,833.2 мянган төгрөгийг зарцуулсан Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8²², Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.5²³-д заасантай тус тус нийцээгүй байна.

Сүмдын Засаг дарга нарт: Малын тоо толгойн албан татварын орлогын эх үүсвэрээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг холбогдох хууль, журамд заасан чиг үүргийн хүрээнд зарцуулах, чиг үүрэгт хамааралгүй зардлыг санхүүжүүлэхгүй байх, малчдын амьдралд үр өгөөжөө өгч, дэмжлэг үзүүлэхүйц төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах

²² малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна.

²³Сум, дүүргийн ОНХС-д төвлөрөх Малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр дараах чиг үүргийн хүрээнд хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ.

Аудитаар малын тоо толгойн албан татварын орлогоос МЭГ-аас ирүүлсэн албан бичгийн дагуу 2022 онд төлөвлөгдөөгүй арга хэмжээг санхүүжүүлж 36,154.4 мянган төгрөгийг зарцуулсан дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Сүмбэр сум 2022 оны мал угаалгын төлбөрт 25,000.0 мянган төгрөгийг “Хийморь-Алтай” МЭҮН-д шилжүүлсэн, шууд худалдан авах босго үнээс давсан байхад худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, гүйцэтгэгч байгууллагад давуу эрх олгосон
- Шивээговь сум 2022 оны мал угаалгын төлбөрт 7,900.0 мянган төгрөгийг “Хийморь-Алтай” МЭҮН-д шилжүүлсэн
- Баянтал сум 2022 оны мал угаалгын төлбөрт 3,254.4 мянган төгрөгийг “Хилийн Дэлгэрэх” МЭҮН-д шилжүүлсэн

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6 "ОНХС-ийн хөрөнгийг ... орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээнд зарцуулахыг хориглоно", гэж заасантай нийцэхгүй байна.

Сумууд дээрх арга хэмжээг санхүүжүүлсэн үндэслэл нь ХХААХҮ-ийн сайд, аймгийн Засаг даргын 2022 оны хамтран ажиллах гэрээнд “Малын тоо толгойн албан татвараас төвлөрсөн санхүүжилтийн 30-аас дээш хувийг мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаанд зарцуулах” гэж тусгасан гэсэн тайлбарыг гаргасан боловч аймгийн Засаг дарга сумдын Засаг дарга нартай байгуулсан гэрээнд энэ чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ төлөвлөөгүй, ямар нэгэн үүрэг хүлээсэн заалт байхгүй байна.



Энэ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 6 дугаар зүйлийн 6.10-д “Сум дүүргийн Засаг дарга нь ОНХС-д төвлөрөх малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр санхүүжүүлэхээр иргэд, малчдаас гаргасан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг журмын 4.5-д заасан чиг үүргийн дагуу боловсруулж, ИТХ-д танилцуулж боловсруулна” гэсэн заалттай нийцээгүй, сумын Засаг даргын төсөв захиран зарцуулах эрхэд хөндлөнгөөс нөлөөлсөн гэж үзэхээр байна.

Аудитын илрүүлэлт: Албан шаардлага

Малын тоо толгойн албан татварын орлогын тайлант онд төлөвлөгдөөгүй төсөл арга хэмжээнд зарцуулж, мал угаалгын төлбөрт нийт 36,154.4 мянган төгрөгийг шилжүүлсэн, босго үнээс хэтэрсэн байхад худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, гүйцэтгэгч байгууллагад давуу эрх олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6²⁴, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлийн

²⁴ орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ.

3.2.²⁵, 3.4.²⁶, 3.4.5²⁷, 5 дугаар зүйлийн 5.8²⁸, 6 дугаар хэсгийн 6.10²⁹, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12 дугаар зүйлийн 12.2.1³⁰, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2³¹, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан “Босго үнэ шинэчлэн батлах тухай” тогтоолд заасантай тус тус нийцээгүй байна

Сумдын Засаг дарга нарт: Малын тоо толгойн албан татварын орлогыг тайлант онд төлөвлөгдөөгүй зардалд зарцуулахгүй байх, төсөл, арга хэмжээний зардал босго үнээс давсан тохиолдолд худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулах

2.2 Малын тоо толгойн албан татварын орлогоор санхүүжүүлсэн хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгасан хэдий ч зарим хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаагүй байна.

2.2.1 Малын тоо толгойн албан татварын орлогын санхүүжилтээр бий болсон хөрөнгийг сумууд данс бүртгэлд бүрэн тусгасан байна.

Малын тоо толгойн албан татварын орлогын санхүүжилтээр 2022-2023 онд нийт 35,496.0 мянган төгрөгийн хөрөнгө бий болсныг хүлээн авч, данс бүртгэлд тусгасан байна. Данс бүртгэлд тусгасан хөрөнгийг сумдаар дараах байдлаар харуулав.

Дүрслэл №06. Данс бүртгэлд тусгасан хөрөнгийн жагсаалт

	/мянган төгрөгөөр/
Баянтал сум-9,946.0	<ul style="list-style-type: none">• Мал угаалгын хашаа-4,500.0 /үндсэн хөрөнгө/• Утагч-2,196.0 /бараа материал/• Нүх ухагч-3,250.0 /бараа материал/
Сүмбэр сум-17,050.0	<ul style="list-style-type: none">• Өвс тэжээл-16,050.0 /бараа материал/• Пос машин-1,000.0 /бараа материал/
Шивээговь сум-8,500.0	<ul style="list-style-type: none">• Өвс тэжээл-8,500.0 /бараа материал/

Эх сурвалж: Сумдын ОНХС-ийн үндсэн хөрөнгө болон бараа материалын журнал

Дүрслэлээс дүгнэхэд: Данс бүртгэлд тусгасан хөрөнгийн 48%-ийг Сүмбэр сум, 28%-ийг Баянтал сум, 24%-ийг Шивээговь сум тус тус эзэлж байна.

2.2.2 Малын тоо толгойн албан татварын орлогоор бий болсон нийт 2,196.0 мянган төгрөгийн 4 ширхэг утагч аппаратыг зориулалтын дагуу ашиглаагүй байна.

²⁵ Тухайн шатны ИТХ-ын тогтоолоор батлагдсан ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний мэдээллийг ИТХ-аас ЗДТГ-ын албан тушаалтанд өгч, тус албан тушаалтан УМС-д оруулна

²⁶ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах гэрээг холбогдох хууль, аргачлал, журамд нийцүүлэн хийх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих

²⁷ ОНХС-ийн УМС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт цэсэд ОНХС-ийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний мэдээллийг бүрэн оруулах

²⁸ Баг, хорооны ИНХ-ын дарга дараагийн төсвийн жилд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг хэлэлцэх, санал хураах хуралдааныг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу хүчин төгөлдөр ирцтэйгээр 6 дугаар сард багтаан зохион байгуулна

²⁹ Сум, дүүргийн Засаг дарга нь ОНХС-д төвлөрөх малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр санхүүжүүлэхээр иргэд, малчдаас гаргасан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг журмын 4.5-д заасан чиг үүргийн дагуу сум, дүүргийн бэлчээр ашиглалт, өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын төлөвлөгөөтэй тус тус уялдуулан боловсруулж ИТХ-д танилцуулж батлуулна.

³⁰ баг, хорооны Засаг дарга орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг хорооны иргэдийн дунд олон нийтийн нээлттэй санал асуулгыг явуулна.

³¹ Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно

Аудитаар малын тоо толгойн албан татварын орлогоор бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж буй эсэхийг тулган баталгаажуулахад: Баянтал сум 2,196.0 мянган төгрөгийн үнэ бүхий бэлчээрийн хортон мэрэгчидтэй тэмцэх зориулалттай 4 ширхэг аппаратыг хүлээн авч, данс бүртгэлд тусгасан боловч хүний биед гэмтэл учруулах эрсдэлтэй гэсэн шалтгаанаар зориулалтын дагуу ашиглаагүй сумын ЗДТГ-ын агуулахад хадгалагдаж байна.



Иймд хүний биед гэмтэл учруулах эрсдэлтэй нөхцөл байдлын шалтгааныг тодруулж, нийлүүлэгч байгууллагад хүсэлт гаргаж хор учруулах эрсдэлийг бууруулан хэвийн ашиглах боломжтой тоног төхөөрөмжөөр солиулж, зориулалтын дагуу ашиглах албан шаардлагыг хүргүүлэв.

БҮЛЭГ 3

Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна

3.1. Малын тоо толгойн албан татварын орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй, удирдлага мэдээллийн системд бүрэн мэдээлээгүй байна.

3.1.1 Малын тоо толгойн албан татварын орлогын бүрдүүлэлт, орлогоос санхүүжих төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Сумдын ИТХ-аас Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар албан татварын хэмжээг тогтоосон шийдвэр гаргасан хэдий ч шийдвэрийн хэрэгжилтэд хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.

Татварын ерөнхий хуулийн 75 дугаар зүйлийн 75.1.2 “татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих”, 75.1.3-д “төсвийн орлогыг бүрдүүлэх” гэж зааснаар аймгийн Татварын хэлтэс нь үндсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, орлого бүрдүүлэлтэд хяналт тавьж ажиллаагүйгээс Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөө 2022 онд 51.5%, 2023 онд 39.1%-иар тус тус тасарсан, малчин, мал бүхий иргэдээс авах 162,043,4 мянган төгрөгийн төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Сумын ИТХ болон Засаг дарга ОНХС-гийн үйл ажиллагааны журмын 3.2.2-д “Тухайн шатны ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих”, 3.4.3-т “сум дүүргийн хэмжээнд ОНХС-ийн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүйгээс малын тоо толгойн албан татварын орлогоос санхүүжих төсөл, арга хэмжээний 2022 онд 33.4%, 2023 онд 36.4% нь хэрэгжээгүй байна.

Аудитын явцад сумдын ИТХ-аас хяналт хэрэгжүүлсэн тайлан мэдээ нотлох баримтыг ирүүлээгүй байна.

ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 9.4-д зааснаар аймгийн СХДАА-аас сумдын ОНХС-ийн 2022, 2023 оны 1-9 дүгээр сарын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, ОНХС-ийн журмын 4.5-д заасан малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээний зарцуулалттай холбоотой нийт 45,523.8 мянган төгрөгийн /Баянтал суманд 7,887.0 мянга, Шивээговь суманд 1,890.1 мянга, Сүмбэр суманд 35,746.7 мянга/ зөрчлийг илрүүлж, зөвлөмж өгсөн байна.

Аудитын илрүүлэлт: Зөвлөмж

Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилт, орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад сумдын ИТХ, Засаг дарга, аймгийн Татварын хэлтсээс хууль журамд заасан чиг үүргийн хүрээнд хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 75 дугаар зүйлийн 75.1.2 “татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих”, 75.1.3-д “төсвийн орлогыг бүрдүүлэх”, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар хэсгийн 3.2.2³², 3.4.3³³-д заасантай тус тус нийцээгүй байна.

Сумдын ИТХ, Засаг дарга, Татварын хэлтэст :Малын тоо толгойн албан татварын хуулийн хэрэгжилт, орлого бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах

3.1.2 Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөө, орлогоос санхүүжсэн төсөл арга хэмжээний мэдээллийг сумд удирдлага мэдээллийн системд бүрэн оруулаагүй байна.

ОНХС-ийн удирдлага мэдээллийн системд малын тоо толгойн албан татварын орлогоос санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, тайлагналыг оруулсан эсэхийг хянан үзэхэд дараах зөрчил илэрсэн байна. Тухайлбал,

- Сүмбэр сум 2022 онд 150,220.1 мянга, 2023 онд 194,803.3 мянган төгрөгийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтын тайланг оруулаагүй
- Шивээговь сум 2022 онд 11,120.5 мянга, 2023 онд 13,462.9 мянган төгрөгийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтын тайланг оруулаагүй
- Баянтал сум 2022 онд 46,907.2 мянган төгрөгийн орлогын бүрдүүлэлт оруулаагүй

Аудитын илрүүлэлт: Албан шаардлага

ОНХС-ийн УМС-д малын тоо толгойн албан татварын орлогоос санхүүжих төсөл арга хэмжээний 2022 онд 208,247.8 мянга, 2023 онд 227,266.2 мянган төгрөгийн мэдээллийг тус тус оруулаагүй байна

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар хэсгийн 3.2.3³⁴, 3.4.5³⁵ дахь заалтуудтай нийцээгүй байна.

Багийн засаг дарга нар ОНХС-ийн арга хэмжээнээс малын тоо толгойн албан татварын орлогоос санхүүжих төсөл арга хэмжээг тусад нь салгаж оруулаагүйгээс шалтгаалсан байна.

Сумд Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалтыг ОНХС-ийн УМС-д нөхөн мэдээлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх, иргэд олон нийтийг мэдээллээр бүрэн хангах

Малын тоо толгойн албан татварын орлого бүрдүүлэлт, зарцуулалтыг Шилэн дансны нэгдсэн системд мэдээлсэн эсэхийг тулган баталгаажуулахад зөрчил илрээгүй байна. Үүнд:

- Сумд нийт 148,839.7 мянган төгрөгийн орлогын төлөвлөгөө, 90,895.0 мянган төгрөгийн орлогын бүрдүүлэлтийг бүрэн мэдээлсэн
- Сумд нийт 86,428.5 мянган төгрөгийн зарцуулалтыг бүрэн мэдээлсэн

³² 3.2.2.Тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих

³³ Сум, дүүргийн хэмжээнд ОНХС-ийн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих

³⁴ ЗДТГ-ын албан тушаалтанд өгч, тус албан тушаалтан Удирдлага мэдээллийн системд оруулна

³⁵ ОНХС-гийн Удирдлага мэдээдлийн системийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт цэсэд ОНХС-ийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний мэдээллийг бүрэн оруулах”

Аудитаар нийт 379,085.8 мянган төгрөгийн зөрчил илэрч, 332,789.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах 8 албан шаардлага, 46,296.2 мянган төгрөгийн 6 зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

1. Төрийн байгууллагуудын мэдээлэл солилцох үйл ажиллагаа удаашралтай байгаагаас Татварын нэгдсэн системд малын тоо толгойн албан татварын ногдуулалт цаг хугацаандаа хийгдээгүй, сумд орлогын төлөвлөлтөд тухайн жилийн татвар ногдуулахад нөлөөлөх хүчин зүйлсийг тооцоогүй, төлөгдөөгүй авлагыг нэмж тооцох болон өмнөх оны татварын орлогын төлөвлөгөөг жишиг байдлаар үндэслэн төлөвлөж иржээ.
2. Малын тоо толгойд ногдуулсан албан татварыг 2022 онд 51.5%, 2023 онд 39.1%-иар дутуу төвлөрүүлсэн нь сумд хариуцсан татварын улсын байцаагч байхгүй, аймгийн Татварын хэлтэс, сумдын Засаг дарга нарын хамтын ажиллагаа үр дүн муутай байгаа нь нөлөөлсөн байна.
3. Малын тоо толгойн албан татварын орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний 34.5 хувь нь орлого бүрэн бүрдээгүйгээс шалтгаалан хэрэгжээгүй байна.
4. Малын тоо толгойн албан татварын орлогоос малчин, мал бүхий иргэдээс өгсөн саналын 28.5%-ийг төсөл, арга хэмжээнд хамруулж, чиг үүрэгт хамааралгүй болон малчдаас санал аваагүй 46 төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн нь малчдын амьдралд чиглэсэн бодит үр дүнгээ үзүүлэх арга хэмжээнд зарцуулагдаж чадахгүй байна.
5. Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилт, орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад сумдын ИТХ, Засаг дарга, аймгийн Татварын хэлтсээс хууль журамд заасан чиг үүргийн хүрээнд хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.
6. Малын тоо толгойн албан татварын орлогоос санхүүжүүлсэн ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн мэдээллийг сумд удирдлага мэдээллийн системд бүрэн оруулаагүй, иргэд олон нийтийг мэдээллээр хангаагүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Сүмдын ИТХ-д:

1. Малын тоо толгойн албан татварын хуулийн хэрэгжилт, орлого бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 3.2-д заасан чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэх

Сүмдын Засаг дарга нарт:

1. Малын тоо толгойн албан татварын орлогыг өмнөх оны мал тооллогын дүн, малчин өрх тус бүрийн мэдээлэлд үндэслэн бодитой төлөвлөх
2. Малын тоо толгойн албан татварын орлогыг малчин, мал бүхий иргэдийн санал аваагүй төсөл арга хэмжээнд батлахгүй байх, багийн ИНХ-аас гаргасан эрэмбэлсэн саналын дагуу хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг санхүүжүүлэх
3. Малын тоо толгойн албан татварын орлогоос чиг үүрэгт хамааралгүй зардлыг санхүүжүүлэхгүй байх, малчдаас өгсөн саналд үндэслэн малчдын амьдралд үр өгөөжөө өгч, дэмжлэг үзүүлэхүйц төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах
4. Малын тоо толгойн албан татварын хуулийн хэрэгжилт, орлого бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах

Аймгийн Татварын хэлтэст:

1. Малын тоо толгойн албан татварын хуулийн хэрэгжилт, орлого бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ САНАЛ

Аудитаар илэрсэн дараах асуудлуудыг шийдвэрлэх талаар холбогдох газарт уламжлуулах саналтай байна. Үүнд:

1. Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан татвар төлөх хугацааг Төсвийн тухай хуультай нийцүүлэх, хуульд өөрчлөлт оруулах саналыг холбогдох байгууллагад уламжлах

Хуулийн хугацаанд өөрчлөлт оруулах нөхцөл байдал: Малын тоо толгойн албан татварын орлого нь ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 2.7-д зааснаар сангийн эх үүсвэрийг бүрдүүлж, журмын 4.5-д заасан арга хэмжээнд зарцуулагдахаар журамлагдсан хэдий ч төсвийн жилийн сүүлээр татварын орлого төвлөрснөөс Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн жилд төлөвлөсөн арга хэмжээг санхүүжүүлэхэд орлого бүрдээгүйгээс төлөвлөсөн арга хэмжээ цаг хугацаандаа хэрэгжихгүй хүндрэл учирч байна

2. “Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-ийн хөгжүүлэлтийг сайжруулах, журамд заасан хугацаанд малчид, мал бүхий этгээдийг “Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-д татвар төлөгчөөр бүртгэж, малын тоо толгойн албан татварын ногдуулалтыг хийх талаар ТЕГ-т уламжлах-

Нөхцөл байдал: Үндэсний Статистикийн хорооны дарга, Татварын газрын даргын хамтран 2022 онд байгуулсан “Мэдээлэл харилцан солилцох гэрээ”- ний 2.2-д мал тооллогын мэдээллийг дараа оны 3 сарын 1-ний дотор Татварын ерөнхий газарт хүргүүлэхээр тусгасан боловч Үндэсний Статистикийн хорооноос мэдээллийг цаг хугацаанд нь хүргүүлэхгүй байна.

Үндэсний Статистикийн хорооноос хууль журам болон гэрээнд заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүйгээс Татварын нэгдсэн системд малын тоо толгойн албан татварын ногдуулалт цаг хугацаандаа хийгдэхгүй байна. Төрийн байгууллагуудын мэдээлэл солилцох үйл ажиллагаа удаашралтай байгаагаас татварын орлого цаг хугацаандаа бүрэн төвлөрөхгүй байх эрсдэлийг бий болгож байна.



ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ




ГОВЬСҮМБЭР АЙМАГ СҮМБЭР СУМЫН ЗАСАГ ДАРГА

200а тоот, Дансранжавын гудамж, Ганзам баг,
Сүмбэр сум, Говьсүмбэр аймаг, 42019
Утас: 7755 3233, Цахим хуудас: www.sumber.ga.gov.mn

2024.06.17 № А/389
танай 2024.06.12-ны № 196 -т

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Б.САРАНТУЯА ТАНАА

Сумын “Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилт, орлогын бүрдүүлэлт, зарцуулалт”-д хийсэн аудитын тайлангийн төсөлд оруулах саналгүй болно.



Т.БАТ-ЭРДЭНЭ

Амгасуудыг
В. Анхрумаг
Ганзоригтай танилцан
Тайланг бүтээх
Төгсгөлөө оруулах

/word/toot/a5.doc



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИНЭГӨВЬ СУМЫН ИРГЭДИЙН
ГОЛОЛОГЧДИЙН ХУРАЛ

Удгээр бол, Шинэговь сум, Говьсүмбэр аймаг, 42031
Утас: 7054 6434.

Цахим хуудас: www.shinegovov.govsumber.khural.mn

2024.06.15 № 1/110

тантай 2024.06.16-ны № 196 -г

АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.САРАНТУЯА ТАНАА

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу “Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилт, орлогын бүрдүүлэлт, зарцуулалт”-д хийсэн аудитын тайлангийн төсөлтэй таницлаа. Тайлангийн төсөлд оруулах санал байхгүй болно.



ДАРГА А.ДЭЛГЭРЗАЯА

Ахлах аудитор
Б.Анхтүвшин
Саналтай танилган
Тайланг болсон
Датгалсануулах

С.Додууян / 17/3



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГА

42030 Говьсүмбэр аймаг, Шивээговь сум,
Утас: 7054 6426. И-мэйл: shivegovt.zibg@gmail.com

2024.06.14 № 1/297

тантай 2024.06.14 № 176

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Б.САРАНТУЯА ТАНАА

Шивээговь сумын 2022, 2023 оны “Малын тоо толгойн албан татварын хэрэгжилт, орлогын бүрдүүлэлт, зарцуулалт”-д Төрийн аудитын газраас хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлангийн төсөлд хүргүүлэх санал байхгүй болно.




Н.СҮГАРМАА

Ахлах аудитор
Б. Анхтүрлэг
Саналтай танилцсан
Тайланг зурвалж
Баталгаажуулах

C:\Documents\B-HITOOT.doc
42524 271

Handwritten signature and date 3/14





ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ

Нутгийн удирдлагын ордон, 1 дүгээр баг,
Баянтал сум, Говьсүмбэр аймаг, 42043
Цахим шуудан: bayantal.ih@gmail.com

2024.06.14 № 31
танай 2024.05.12 -ны № 176 -т

Төсөлд санал хүргүүлэх тухай

“Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилт, орлогын бүрдүүлэлт, зарцуулалт”-д хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцсан бөгөөд төсөлтэй холбоотой санал байхгүй болно.

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Ахлах аудитор
Б. Анхоржав

Саналтай танилцсан
Тайланг хүлээн
Баталгаажуулах

[Signature]
17/14

НАРИЙН БИЧГИЙН ДААРИЙН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д. СУВД-ЭРДЭНЭ



**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ТАТВАРЫН ГАЗАР**

Найрамдал хотхон 276, 3 дугаар баг,
Сүмбэр сум, Говьсүмбэр аймаг, 42015
Утас: 7054 0011, Цахим шуудан: gobisumber@mta.gov.mn

2024.06.14 № 03/215
танай 2024.06.12-ны № А76 -т

**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР-Т**

“Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилт, орлогын бүрдүүлэлт, зарцуулалт” сэдэвт нийцлийн аудитын дүгнэлтийн хариу тайлбар гарган хүргүүлж байна.

Хавсралт: хуудас

ДАРГА



П.ЭНХ-ОЮУН

*Ахлах аудитор
В. Амарсүрэн*
Сониртой тайлбар
Тайлбар өргөлт
орчуулах зэрэг ажил
Тиймшгүүрх
В. Амарсүрэн 7/14

Documents/Documents/Word/Toot/A5 .do

4224300114

Говьсүмбэр аймгийн Татварын газрын 2024 оны
06 сарын 14-ийн өдрийн 213 тоотын хавсралт

**“МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ,
ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ” СЭДЭВТ НИЙЦЛИЙН АУДИТАД
ХИЙСЭН ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ**

1.1.3 Малын тоо толгойн албан татварын ногдуулалт бүрэн хийгдсэн эсэхийг тогтоох боломжгүй байна.

ҮСХ-ноос гаргасан малтай өрхийн тоог Татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд татвар төлөгчөөр бүртгэгдсэн малтай өрхийн тоотой харьцуулахад 2022 онд 113, 2023 онд 219-өөр тус тус илүү байна.

ҮСХ-ны мал тооллогын дүнгээр аймгийн хэмжээнд 2021 онд 432196 толгой, 2022 онд 7.4%-аар өсөж 464294 толгой мал тус тус тоологдсон байна. Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд ногдуулсан малын тоо толгойг ҮСХ ноос гаргасан малын тоо толгойн дүнтэй тулгах гэсэн боловч Аймгийн Татварын газрын татвар ногдуулсан малын тоо мэдээллийн сангаас хөрвөдөггүй, гарах боломжгүй гэсэн хариу өгсөн байна. Иймд малын тоо толгойн албан татварын ногдуулалт бүрэн үүссэн эсэхийг тогтоох боломжгүй байна.

Тайлбар: Малын тоо толгойн албан татвар төлөгчийн тоон мэдээлэл нь Татварын удирдлагын нэгдсэн системийн хөгжүүлэлтийн явцад алдаатай татагдсан тул өмнө хүргүүлсэн тоон мэдээллийг залруулах санал гарган хүргүүлж байна.

Малчин өрх, мал бүхий этгээд нь татварын цахим тайлангийн системээр малын тоо толгойн албан татварын тайлангаа илгээдэг. Үндэсний статистикийн хорооны мэдээлэлтэй 2022 онд 28, 2023 онд 31-ээр зөрүүтэй байгаа нь Улсын бүртгэл дээр шилжүүлсэн боловч цахим тайлангийн системээр харъяалагдах татварын албаа шилжүүлээгүйн улмаас 2 өөр албанд тайлагнах, мөн малчдын отор нүүдэл, бэлчээрийн нөхцөл байдал, туслах малчидтай холбоотой бод болон бог малаа 2-3 аймгийн нутаг дэвсгэрт тоолуулж, хариулж маллах зэрэг шалтгааны улмаас 2-3 өөр албанд тайлагнах тохиолдол гардаг.

Сумдын нэрс	Малтай өрхийн тоо /2022/			
	Татвар	Үүнээс: ААНБ	ҮСХ	зөрүү
Баянтал	166	1	160	6
Сүмбэр	839	6	830	9
Шивээговь	189	1	176	13
	1194	8	1166	28



ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Шивээговь, Баянтал сумдын ИТХ, Сүмбэр, Шивээговь, Баянтал сумдын Засаг дарга, аймгийн Татварын газраас ирүүлсэн саналтай танилцлаа. Аймгийн Татварын газрын ирүүлсэн Татварын удирдлагын нэгдсэн системээс малчид, мал бүхий этгээдийн тоо алдаатай татсан саналыг хүлээн авч, малтай өрхийн тоонд өөрчлөлт оруулсан болно.



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 06 сарын 21 өдөр

Дугаар

A/13

Чайр

Аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 18.9, 18.10 дахь заалт, “Эрх шилжүүлэх тухай” 2023 оны А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилт, орлогын бүрдүүлэлт, зарцуулалт”-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, сумдын Засаг дарга, аймгийн Татварын газарт тус тус хүргүүлэхийг ахлах аудитор (Б.Анхтуяа)-д даалгасугай.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг арилган, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, түүний үр дүнг 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Шивээговь, Баянтал сумдын ИТХ-ын дарга, сумдын Засаг дарга нарт тус тус зөвлөсүгэй.
4. Аудитын зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг ахлах аудитор (Б.Анхтуяа)-д үүрэг болгосугай.
5. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (ахлах аудитор Б.Анхтуяа, аудитор С.Батцэцэг)-т даалгасугай.
6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Г.Наранбаяр)-т даалгасугай.



Б.САРАНТУЯА

D:\DOTOOD AJIL\TUSHAAL.doc
008010647